



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН “ХУСТАЙН” ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ХҮННУ СТИЙЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ГАНЗОРИГ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН “ХУСТАЙН” ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БАЙРШИЛ: СЭЛЭНГЭ АЙМАГ, ЕРӨӨ СУМ
РЕГИСТРИЙН ДУГААР: 5378834**

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ..... /Ц.ЖАРГАЛНЭМЭХ/

БОЛОВСРУУЛСАН:

“ХҮННУ СТИЙЛ” ХХК-ИЙН МЭРГЭЖИЛТЭН/Д.БАТДОРЖ/

2025 ОН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
2.1 Төслийн талбайн байршил.....	2
2.2 Уулын ажлын төлөвлөгөө.....	2
2.3. Нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөв.....	3
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
3.1 Газрын гадарга, хэвлий.....	4
3.2 Агаарын чанар.....	4
3.3 Уур амьсгал.....	4
3.4 Гадаргын болон газрын доорх ус.....	4
3.5 Ургалан нөмрөг.....	5
3.6 Амьтны аймаг.....	5
3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.....	5
3.8 Нийгэм, эдийн засаг.....	5
3.9 Түүх, соёлын дурсгалт газар.....	6
3.10 Хаягдлын менежмент.....	6
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	7
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	7
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	20
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч “ХҮННҮ СТИЙЛ” ХХК нь Сэлэнгэ амйгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт орших “Хустай”-н төмрийн хүдрийн орд (MV-017017)-ыг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-ийг 2020 онд шинэчлэн боловсруулж Геологи-хайгуулын судалгаагаар ордыг ил уурхайн аргаар нийт 10 жил ашиглана.

“Хүннү стийл” ХХК нь Монгол улсын 5378834 тоот регистрийн дугаартай, 9011237003 тоот бүртгэлийн гэрчилгээтэй аж ахуйн нэгж нь “Хустайн” төмрийн ордын MV-017017 тоот дугаартай 84,73 га ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд 2012 оны нөөцийн үр дүнгийн тайлан батлагдсан уг талбайд төмрийн хүдрийн ордыг эргэлтэнд оруулах, Монгол улс дахь металлургийн үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон эерэг талтай хэмээн үзэж уг ордыг ашиглахаар тусгай зөвшөөрөл авсан болно.

“Хустайн төмрийн орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах ба сумын төвөөс зүүн урагш 22 км-т, Аймгийн төвөөс зүүн урагш 102 км-т, Улаанбаатар хотоос хойд зүгт-т 330 км-т, Дархан-Уул аймгаас зүүн хойд зүгт 110 км-т байрлана.

Төслийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн 2018.11.07-ны өдрийн 13/7918 тоот дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу “Цагаан Уулын Оргил” ХХК хийж гүйцэтгэв.

Тус ашиглалтын талбайд 2012 онд хайгуулын ажил хийгдэж нийт хүдэр В нөөц 5.524.7 мян.тн, С нөөц 4.964.4 мян.тн, В+С нөөц 10.489.1 мян.тн батлагдсан.


Хустай уурхай нь анх байгуулагдсанаас хойш орон нутгийг иргэдийг ажлын байраар хангах бодлого барин ажиллаж байна. Тус уурхайд Улаанбаатар хот болон Дархан-Уул аймаг, орон нутгийн харъяалалтай 50-иад ажилтан ажиллаж байна.

“Хүннү стийл” ХХК нь “Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах, ил аргаар олборлох Хустай төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар журмын хавсралт 3-ын дагуу боловсруулав.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбайн байршил

Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Буургачин багт Хустайн ар хэсэгт оршдог. Улаанбаатар хотоос хойд зүгт 330 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 16 км, Дархан хотоос хойд зүгт 110 км зайтай. (Зураг 1-ээс дэлгэрэнгүй харах).



Зураг 1. Төслийн ерөнхий байршил.

2.2 Уулын ажлын ерөнхий мэдээлэл

Төслөөр уурхайн хил хязгаар дотор 10,965.3 мян.тн хүдэр үйлдвэрлэлийн нөөц олборлож, нийт 40,599.5 мян.м³ хөрс хуулахаар тооцоологдсон.

Батлагдсан нөөцийн дагуу ил уурхай, хуурай соронзон бажуулах үйлдвэр ажиллаж байгаа бөгөөд төмрийн хүдрийг гарган авахын тулд хуурай соронзон сеператорыг ашиглан баяжуулж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар томилогдсон Улсын комисс 2024 оны 07 дугаар 05-ны өдөр тус компанийн уурхай, үйлдвэрт ажиллаж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүрдүүлбэл зохих бичиг баримттай танилцаад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/303 тоот тушаалаар баталсан журмын 2.2-т заасны дагуу “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх бэлтгэл ажил”-ыг хангасан гэж үзэн хүлээн авсан.

2.5 Нийгэм эдийн засгийн ерөнхий төлөв

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын газар нутгийн 19.76%-ийг эзэлдэг бөгөөд аймгийн нийт хүн амын 5.9% нь оршин суудаг. Хүн амын нягтрал нь 1 га тайлбайд 0.8 хүн ноогддог. Хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас 5-д, газар нутгийн хэмжээгээр 1-рт ордог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 820.3 га.

Ерөө сумын газар ашиглалтын байдлаас харахад нийт газар нутгийн хамгийн и буюу 61.02%-ийг ойн сан бүхий газар, 23.5%-ийг хөдөө аж ахуйн газар, 13.6%-ийг тусгай хэрэгцээний газар, 0.6%-ийг усан сан бүхий газар, 0.9%-ийг тосгон суурины газар, 0.2%-ийг дэд бүтцийн газар эзлэж байна.

Улаанбаатар Дархан хотын томоохон зах зээлд ойрхон. Монгол улсын хөгжлийг тэтгэх олон улсын чанартай төмөр замтай. Хуучин аж ахуйн барилга байгууламжтай, ажиллах хүчний нөөцтэй. Эдийн засгийн голлох салбар нь газар тариалан, мал аж ахуй, фермерийн аж ахуй болон ашигт малтмалын нөөцтэй. Өндөр ашиг шимт малын үүлдэр угсаатай. Шинээр үйлдвэрлэл аж ахуйн газар байгуулах болон иргэний зориулалттай байшин барилга барих газрын нөөцтэй. Өрхийн үйлдвэрлэл нэмэгдэж байна. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжтой. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутагт хамрагддаг. Хүнсний худалдааны цэг салбарын хүрэлцээ хангалттай, барааны үнэ боломжийн гэж болно. Хүн амын өсөлт нэмэгдэж байгаа. Шилэн кабельд холбогдсон. Үүрэн телефоны бүх оператортой .

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хустайн төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Ил уурхай үүсгэх;
2. Гадаад овоолго байгуулах;
3. Газрын доорх усны нөөцийг ашиглах, шүүрүүлэх;
4. Уурхайн шүүрсэн усыг зайлуулах;
5. Олон тооны дизель генератор зэрэг ажиллуулах;
6. Хүдэр хадгалах тайлбай байгуулах;
7. Тэсэлгээний ажил гүйцэтгэх;
8. Уурхайн дотоод ба гадаад тээвэрлэлтийг гүйцэтгэх;
9. Орд газрын эргэн тойронд шинээр шороон зам бий болгох;
10. Технологийн болон ахуйн гаралтай хог хаягдлын цэг-талбай байгуулах;

Тус ордоос ил аргаар төмрийн хүдэр олборлох үйл ажиллагааны улмаас дунджаар 84.7 га талбайн хөрс, ургамлан бүрхэвч эвдрэлд өртөх болно. Уурхайн эдэлбэрт өртөгдөх талбайн хэмжээг ашиглалтын төрөл тус бүрээр доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Уурхайн эдэлбэрт өртөх талбайн хэмжээ

№	Эвдрэл үүсэх талбай	Эвдрэлийн шинж	Талбай, га
1	Ил уурхайн талбай	Ашиглалтын төгсгөлд 240м гүн, 500м урт, 300м өргөн ухаш	28.4
2	Үйлдэрлэлийн талбай	Баяжуулах үйлдвэр бусад барилга байгууламж	8
3	Засварын газар	Уурхайн засварын газар	1.1
4	Тосгон	Уурхайн тосгон байгуулахад уг талбайг ашиглана.	5.6
5	Овоолгууд -Хөрсний зүүн овоолго	Овоолгууд үүсэхэд эзлэгдэнэ	32
	Баяжуулалтын хаягдлын овоолго		4.2
6	Уурхайн технологийн зам	Авто зам Бугант сум орох сайжруулсан шороон зам	5.4
Нийт			84.7

3.1 Газрын гадарга, хэвлий.

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь дунд хугацааны хүчтэй нөлөөлөл юм. Төслийн үйл ажиллагаанаас ордын нийт тайлбай шууд сөрөг нөлөөлөлд эрчимтэй өртөнө. Ордыг ил уурхайн технологиор олборлох төслийн хүрээнд нийт 38.8 сая.тн уулын ажил хийгдэнэ. Уурхайн барилга байгууламж, уурхайн дотоод, гадаад зам, үерийн шуудуу суваг зэрэг технологийн нөлөөллүүд үүснэ. Газрын хэвлий ухагдан хөндий орон зай үүсч, ландшафтын хэлбэр дүрс хүчтэй өөрчлөгдөн байгалийн унаган төрх алдагдана.

3.2 Агаарын чанар.

Тухайн бүс нутагт голын хөндий нам газартаа өвөл илүү хүйтэн, зун илүү халдаг байхад энгэр эзвэр, өндөрлөг газар өвөл харьцангуй дулаан, зун сэрүүн байдаг зүй тогтол Ерөө, Бугант орчимд тод илэрдэг бөгөөд хүйтэн улирлын агаарын дундаж температур $-20-25^{\circ}\text{C}$, дулааны улирлын агаарын дундаж температур $+16+17^{\circ}\text{C}$ байна. Олон жилийн дундаж агаарын температур $-1.1....+0.1^{\circ}\text{C}$ орчим байдаг.

Салхины зонхилох чиглэл XI, XII, I саруудад зүүн хойд болон зүүн зүгээс байгаа бол II,III саруудад зүүн болон зүүн хойд зүгээс, IV сард хойд зүгээс илүү давамгайлдаг байна. Харин салхины чиглэл V сард хойд зүгээс илүү давамгайлж байхад VI, VII саруудад баруун болон өмнө зүгээс илүү салхилж, намрын улирал VIII, XI саруудад өмнө зүгээс, X сард хойд зүгээс илүү салхилдаг.

3.3 Уур амьсгал.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг нь уур амьсгалын мужлалаар дулаавтар зунтай хагас чийглэг мужид хамаарна. Хавар оройн хүйтрэлтийн хугацаа дунджаар 5-р сарын дунд үеэс 6-р сарын эхний 10 хоногт, намрын эхний хүйтрэлт 8-р сарын сүүлийн 10 хоногоос 9-р сарын эхний 10 хоногт, намрын эхний хүйтрэлт 8-р сарын сүүлийн 10 хоногоос 9-р сарын эхний 10 хоногт тохиолдоно. Мөн энэ үеэр анхны цас ордог бөгөөд жилд дунджаар 80-90 хоног цасан бүрхүүлтэй байдаг.

Бүс нутагт тогтмол их буюу бараг 400 мм хур тунадас унадаг. Жилийн хур тунадасны 95% нь дулааны улиралд (үүний 70% нь зуны 3 сард), 5% нь 11-3 дугаар сарын хүйтний улиралд ордог байна. Жилд 47 өдөр цас, 49 өдөр бороо, 1-2 өдөр мөндөр ордог байна.

Салхины зонхилох чиглэл XI, XII, I саруудад зүүн хойд болон зүүн зүгээс байдаг бол 2, 3 саруудад зүүн болон зүүн хойд зүгээс, IV сард хойд зүгээс илүү давамгайлдаг байна.

3.4 Гадаргын болон газрын доорх ус.

Тусгай зөвшөөрлийн талбайд явуулах аливаа үйл ажиллагаа нь ойр орчим дахь сайо судгын голдирол, түүний дагуух булаг шанд, түүнчлэн гар худаг, гүний усны нөөц горим, чанарт сөрөг нөлөө үзүүлэх нөхцөлтэй.

Төслийн талбайд явуулах аливаа үйл ажиллагаа ургамлын бүрхэвчийг доройтуулж, хөрсийг дагтаршуулах, элэгдүүлэх, эвдэх зэргээс болж үерийн урсацын коэффициентийг ихэсгэнэ. Энэ нь үерийн урсац, хамгийн их өнгөрөлтийг дээрх их урсацын тооцооноос ч нэмэгдүүлэх эрсдэлтэй бөгөөд сайр ба хажуугийн урсацын уруйн үер уул уурхай, үйлдвэрийн талбай усанд автах, ус тогтох гэх мэт сөрөг нөлөө үзүүлэх болно.

Судалгааны талбай нь байнгын урсгалтай гол горхи, булаг шанд элбэгтэй. Газрын доорх урсацын хөдөлгөөнд тулалт (подпор)-ууд үүсэх ба газрын гүний байгалийн тогтоц өөрчлөгдөх. Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, бохир усны алдагдал, нэвчилтээс бага гүний уст үеүд бохирдох. Хаягдал чулуулгийн овоолгыг газрын гадарга дээр бий болгосноор хүчил үүсэх боломжтой ба ингэснээр хур борооны үед уурхайн хаягдал чулуулгийн овоолгоос хүчиллэг уусмал шүрч хүчиллэг урсац үүсч болзошгүй

3.5 Ургамлан нөмрөг.

Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байрлалтай судалгааны талбай орчим нь ургамал газар зүйн тойргийн ангиллаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойргийн захад хамрагдана. Хээрийн судалгаагаар ургамалжлын хувьд талбайн баруун ба зүүн талаар уул толгодоор хашигдсан дундаа жалга гуутай уул хоорондын хөндийн ургамалжилттай. Лецензийн талбайд ургаж байгаа дээд ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивэл, нүцгэн үртэний хүрээний хамааралтай ургамалгүй, далд үртний хүрээний 63 зүйл (үүнээс нэг талтан 15 зүйл, хос талтан 48 зүйл) байна.

3.6 Амьтны аймаг.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Хустайн”-н төмрийн хүдрийн орд түүний хил залгаа нутагт тархсан шавж идэштэн 4, сарьсан далавчтан 4, туулай хэлбэртэн 3, мэрэгчтэн 9, мах идэштэн 8, туруутан 3 зүйл нийт 6 багт хамаарах 31 зүйлийн хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоож хамгааллын статусыг нэгтгэн тодорхойлов.

3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.

Төсөл хэрэгжих талбайд улсын тусгай хамгаалалттай газар нутагт байхгүй. Хан-Хэнтийн Дархан цаазат газраас төсөл хэрэгжих талбай нь ойролцоогоор 86 км-ийн зайд, Тужийн нарс байгалийн цогцолборт газраас 39 км-ийн зайд байна. Иймээс уурхайн үйл ажиллагаа тус тусгай хамгаалалттай газарт шуулд нөлөөлөл үзүүлэхгүй.

3.8 Төсөл хэрэгжих орчны нийгэм-эдийн засаг

Ерөө сум нь Сэлэнгэ аймгийн нийт газар нутгийн 19.76%-ийг эзэлдэг бөгөөд аймгийн нийт хүн амын 5.9% нь оршин суудаг. Хүн амын нягтрал нь 1 га тайлбайд 0.8 хүн ноогддог. Хүн амын тоогоороо Сэлэнгэ аймгийн 17 сумаас 5-д, газар нутгийн хэмжээгээр 1-рт ордог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 820.3 га.

Ерөө сумын газар ашиглалтын байдлаас харахад нийт газар нутгийн хамгийн буюу 61.02%-ийг ойн сан бүхий газар, 23.5%-ийг хөдөө аж ахуйн газар, 13.6%-ийг тусгай хэрэгцээний газар, 0.6%-ийг усан сан бүхий газар, 0.9%-ийг тосгон суурины газар, 0.2%-ийг дэд бүтцийн газар эзлэж байна.

Тавин, Буурагчин, Бугант гэсэн 3 багийн нийт 1862 өрхөд 6567 хүн амьдардаг. 2 баг нь сумын төвд Буганд тосгон нь сумын төвөөс 75 км зайд байрладаг. Хүн амын 43.1%-ийг залуучууд, 30.8%-ийг хүүхэд багачууд эзэлж байна.

Ерөө сумын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор 80.6 мян.толгой мал тоолуулсан байна. Үүнээс адуу 6.9%-ийг, үхэр 18.4%-ийг хонь, 37.4%-ийг ямаа, 37.2%-ийг тус тус эзэлж байна.

Сумын хэмжээнд нийт 23,300 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 15га-д төмс, 50га-д хүнсний ногоо, 50%-д улаан буудай, 35%-д талбайд тэжээлийн бусад ургамал тариалж байна.

Улаанбаатар Дархан хотын томоохон зах зээлд ойрхон. Монгол улсын хөгжлийг тэтгэх олон улсын чанартай төмөр замтай. Хуучин аж ахуйн барилга байгууламжтай, ажиллах хүчний нөөцтэй. Эдийн засгийн голлох салбар нь газар тариалан, мал аж ахуй, фермерийн аж ахуй болон ашигт малтмалын нөөцтэй. Өндөр ашиг шимт малын үүлдэр угсаатай. Шинээр үйлдвэрлэл аж ахуйн газар байгуулах болон иргэний зориулалттай байшин барилга барих газрын нөөцтэй. Өрхийн үйлдвэрлэл нэмэгдэж байна. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжтой. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутагт хамрагддаг. Хүнсний худалдааны цэг салбарын хүрэлцээ хангалттай, барааны үнэ боломжийн гэж болно. Хүн амын өсөлт нэмэгдэж байгаа. Шилэн кабельд холбогдсон. Үүрэн телефоны бүх оператортой .

3.9 Түүх, соёлын дурсгалт зүйлс. Төсөл хэрэгжих талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

3.10 Хаягдлын менежмент.

Үйлдвэрийн хаягдлын аж ахуй нь боловсруулалтаас 32.5%-ийн гарцтай хаягдал үүснэ. Овоолго нь хуурай хаягдал байх ба ашиглалтын явцад үүсэх хаягдлын хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3.

Хаягдлын төрөл	Бүлгийн код	Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Хэмжих нэгж	Жилд гарах хэмжээ	Дахин ашиглалт	Устгал
Ахуйн хаягдал	20 03 01	Холимог ахуйн хатуу хог хаягдал	Уурхайн ажилчид	тн	42		тийм
	20 03 99	Шингэн хаягдал					
Үйлдвэрлэлийн хаягдал	16 04 02	Тэсрэх бодисын сав, баглаа	Ил уурхай	тн	12.6		Хадгалах
	01 01 01	Металлын хүдрийн олборлолтын хаягдал	Үйлдвэр		356.4		

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино.

Гол зорилтууд: Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг өмнөх оны дүгнэх хуудсыг үндэслэн жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт).

Төслийн 2021-2025 он хүртэл 5 жилийн БОМТ-г байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах “ хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт зардал урьдчилсан байдлаар 44,790,000 сая.төг,

Хүснэгт 4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д/д	Авах арга хэмжээний нэр	Зардал, төгрөг
		2025 он
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	-
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	900,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600,000
5	Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	290,000
6	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	500,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	500,000
8	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	42,000,000
9	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
2025 оны нийт зардал, төгрөг		44,790,000

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг Монгол Улсын байгаль орчны багц хуулиудаар тавигдсан шаардлага, БОАЖЯ-ны 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, БОННУ-ний хүрээнд боловсруулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардлагуудыг үндэслэн тодорхойлов.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, (төгрөг)	Нийт зардал, (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Уурхайн хүнд машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмын үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Осол эрсдлээс сэргийлэх	-	-	Уурхайн дотоод зардлаар		жилд 1 удаа	“Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль” MNS 4585:2016 MNS 4597:2013 MNS 5885:2008
Уурхайн дотоод тээврийн зам, овоолго зэргийг хуурайшилттай үед чийглэх болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайг усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах	Тоосжилтоос сэргийлэх	-	-	Уурхайн үйл ажиллагааны зардлаар		хуурайшилтын улиралд өдөр бүр бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна	Агаарын тухай хууль MNS 4585:2007 MNS ISO 4227:2002 MNS 4990:2015
Дүн								

2. ХӨРС БА УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР							
Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө.	Уурхайд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлэх, 30км/цаг-аас хэтрүүлэхгүй байх.	Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах	-	-	Уурхайн дотоод зардлаар	(ашиглалтын явцад тодорхой төлөвлөгөөний дагуу арчилж тордож нэмэгдүүлж байх)	MNS 5915:2008 “БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5917:2008 “уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага”
Үржил шимт өнгөн хөрсийг хуулан авч тусгайлан овоолго байгуулж нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгалах	Үржил шимт өнгөн хөрсийг нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгалах	Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах	-	-	Уурхайн үйл ажиллагааны зардлаас	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэх	MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5916:2008 “БО. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”

Дүн								
3. ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Усан хангамжид ашиглах худгийг тоолууржуулах	Худаг	ш	1	500,000	500,000	Тоолуурууд гацсан гэмтсэн болон шинээр эх үүсвэр ашиглах болсон тухай бүр солих арга хэмжээ авах,	Усны тухай хууль Усны нөөцийг хамгаалах журам. БО болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал 143/А/352 MNS 0900:2018 MNS 4586:1198
Дүн						500,000		
4. АМЬТНЫ АЙМАГ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Үйл ажиллагаанаас амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулах Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүй байх арга хэмжээ авах	Тэмдэг тэмдэглдэгээ тавих, салаа зам гаргахгүй байх.	-	-	-	1,000,000	Жилдээ 1 удаа	“Амьтны аймгийн тухай” хууль 6-р зүйл: 6.1.3, 6.1.4, 6.1.6, 6.1.7, 6.1.8, 25-р зүйл “Ан агнуурын тухай” хууль

Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр"-ийг Сэлэнгэ аймгийн Байгаль орчин Аялал Жуулчлалын Газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	-	-		42,000,000	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн зардлаар	Жилдээ 1 удаа	
Дүн						43,000,000		
Нийт дүн								

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж (га)	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР								
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тариалах	Нарсны суулгац тариалах арга хэмжээг зохион байгуулах	Кемпийн хашаанд	1	5000	250	1,250,000 Үйл ажиллагааны зардлаас	2 удаа (хавар, намар)	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Дүн						1,250,000		
Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг бульдозероор хуулах, хураах ажил	Уурхайн эдэлбэр газар	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 25,2
	Шимт хөрсийг тараах, шимт хөрсөөр хучих ажил		-	-	-	Үйл ажиллагааны зардлаас		
	Орчны тоосжилт болон салхины							

Биологийн нөхөн сэргээлт	хурд бууруулах, зорилгоор мод бут тарих, орчныг ургамалжуулах, овоолгын гадаргуу, хажууг хэлбэршүүлэх, олон наст ургамал тарих	Уурхайн эдэлбэр газар	-	-	-	-	Ашиглалтын 5 дахь жилээс	MNS5916:2008
	Ургамалжуулах ажил		-	-	-	-		“Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7-р зүйл Газрын хэвлийн тухай хууль 41.1-4
	Хөрс сайжруулалт ба усалгааны ажил		-	-	-	-		
Нийт дүн						1,250,000		

БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР								
Галын аюул, хээрийн түймэр	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах байнгын бэлэн байлгах	Үйлдвэрийн хүрээнд	ш	300,000	3	900,000	Төслийн хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль 27.1
	Аюул гарц заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Үйлдвэрийн хүрээнд	ш	50,000	5	250,000		Галын аюулгүй байдлын тухай 16-1, 2, 18-1, 2, 19-1,2 20-1,2, 21-1, 2, 3 БНБД 21-01-02 Барилгын гал тэсвэршилтийн зэрэг

Хүчтэй салхи, шуурга, аянга цахилгааны осол	Хүчтэй салхи, шуурганы үед үзэгдэх орчин хязгаарлагдсан үед уурхайн тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг ажлыг түр хугацаанд зогсоох	Үйлдвэрийн хүрээнд	-	-			Шаадлагатай үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хамгаалалтын хувцас Ерөнхий шаардлага MNS (ISO) 13688:2000
	Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байршуулах	Үйлдвэрийн хүрээнд	ш	-			Төслийн хугацаанд	
Дүн						1,150,000		
2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР								
Хяналтаас гадуурх тэсэлгээний ажил	Тэсэлгээний ажлыг нарийн төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэдэг байх	Үйлдвэрийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр	Үйлдвэрийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	

	хангах							
Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Өдөр бүр	Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага MNS (ISO) 13688:2000
Машин техникийн осол	Жолооч бүрийг даатгалд хамруулах	Үйлдвэрийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Жилд 1 удаа	
	Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах		-	-	-		Төслийн хугацаанд	
Дүн								
Нийт дүн						1,150,000		

БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Үүсэх ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Хог хаягдлын цэг	Жилд		1,200,000		Хамтран ажиллах гэрээний дагуу /Сард 1 удаа Ерөө сум/	Хог хаягдлын тухай хууль БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний Өдрийн А/445 дугаар тушаал БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаал
	Бохирын цооногт 1м ³ бохирт 1л био бэлдмэл байхаар тооцож тогтмол ариутгал хийх							
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга	Төслийн бүх төрлийн байгууламжууд						

	хэмжээнүүдийг тодорхойлох					БОАЖЯ-ын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/18 тушаал	
Аюултай	Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах	Машин механизмын үйлчилгээний үеийн хаягдал Аюултай хог хаягдлыг устгах,хадгалах тусгай зөвшөөрөлтэй хамтран ажиллах	Жилд				Үйл ажиллагааны гэрээний дагуу хог хаягдал нийлүүлтээс хамаарна
	Тээвэрлэх үйлчилгээний хөлс						
Нийт дүн				1,200,000			

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, (төгрөг)	Нийт зардал, (төгрөг)	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР							
Тоосжилт /pm-2.5 pm-10/ Агаар дахь бодисын найрлага	Баяжуулах үйлдвэр Ил уурхай, овоолгын доор	Жилд 2 удаа	2 удаа	104'500	209'000	Үйл ажиллагаа жигдэрсэн	Агаарын чанар Техникийн ерөнхий

тодорхойлох /NO2,SO2/	болон хаягдлын сан					үед хэмжих	шаардлага MNS 4585:2016 MNS 5919:2008 MNS 5013 :2001 MNS ISO 4221: 2002, MNS 5365:2004
Дүн					209'000		
2.ГАЗРЫН ДООРХ УС							
Ундны усанд ашиглагдаж байгаа гүний худгаас химийн шинжилгээ. Худгийн уснаас баактерлогийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабраторт өгөх	Ашиглагдаж буй худаг	Жилд 2 удаа	2 удаа	65,000	130,000	Уурхайн үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	MNS 0900:2005 (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667- 11:2000 MNS (ISO) 5667- 1:2002
Дүн					130'000		
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
Нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох, Хүнд метиалл Тусгай зөвшөөрөлийн талбайд хөрсөнд агрохимийн шинжилгээ хийлгэх	Авто зогсоол, засварын газар, ШТС	Жилд 2 удаа		Агрохими- 68,500x4=274,000 Хүнд метиал- 45,000x2=90,000 Нефт- 50,000x2=100,000	464,000	Үйл ажиллагаа жигдэрсэн үед хэмжих	MNS 5850:2019 MNS3297:1991 MNS:2305:1994 MNS:3298:1991

Дүн	464'000		
Нийт дүн	803,000		

БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, уурхайн ашиглалтын явцад үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав. (Хүснэгт 10)

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
Сумын захиргаатай хамтран уурхайд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах	Сэлэнгэ аймаг Ерөө сумдын иргэд	-	I-IV Улирал	Компанийн удирдлага Хүний нөөц
БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах	Гэрээт байгууллагаар хийлгэх	Дотоод үйл ажиллагааны зардлаас	Төслийн хугацаанд	Компанийн удирдлага Байгаль орчны мэргэжилтэн
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Байгаль орчны мэргэжилтэн	Дотоод үйл ажиллагааны зардлаас	Төслийн хугацаанд	Компанийн удирдлага Байгаль орчны мэргэжилтэн

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ-г боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилго юм. (Хүснэгт 11)

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, (төгрөг)
Иргэд, багийн ИНХ	Тайлагнах, хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн 10 сард	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулах	Компанийн байранд	Үйл ажиллагааны зардлаас
Аймгийн байгаль орчны газар	Тайлагнах	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сард	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	Аймгийн байгаль орчны газарт	Үйл ажиллагааны зардлаас

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12 дугаар сарын 10-аас өмнө	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Үйл ажиллагааны зардлаас
Нийт дүн						-